



АЛТАНБУЛАГ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУД ТУСГАЙ САНГУУД

2013 оны САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

Т.Майцэцэг - Ахлах аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Алтанбулаг сумын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Алтанбулаг сумын 2013 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Алтанбулаг сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

**Гол санхүүгийн хяналтууд
хамрагдсаныг тодруулбал:**

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

**Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр
дүнгээс гарсныг торуулбал:**

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 74755.8 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 92416.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 17660.3 мянган төгрөгөөр буюу 123.6 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 36095.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба жилийн эцэст 13951.7 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн. Орон нутгийн орлогын дансны орлого, зарлагын гүйлгээ 1684.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
- Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд Нэмэлт төсвийн дансны санхүүжилтийг 12865.1 мянган төгрөгөөр илүү нэгтгэснийг болон СХСангийн авлага 147503.9 мянган төгрөгийг орхигдуулсныг нэмж нэгтгүүлсэн болно.
- МХСангийн орлогыг 1834.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, нэгтгэсэн

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж
авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх
зөрчлүүд материаллагын урьдчилан
тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй
санал дүгнэлт гаргахаар **Т э р г ү ү л э х**
а у д и т о р т с а н а л о р у у л с а н
б а й г а а

- ҮАГазрын харьяа Төв аймгийн
Аудитын Газрын дарга, Тэргүүлэх
Аудитор 2014.03.24 -ны өдөр санал
дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч,
нярав болон бусад албан тушаалтан
бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд
дэмжлэг болж байсанд гүнээ талархаж
байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.22

Танилцуулга

Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Алтанбулаг сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Алтанбулаг сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Алтанбулаг сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Санхүүгийн дотоод хяналтын талаар

Сумын хэмжээгээр төрийн сангийн зүгээс байгууллагуудын санхүүд хяналт шалгалт хийсэн тайлан материал ирүүлээгүй болно.

Орлого санхүүжилтийн талаар:

Алтанбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012.12.20-ний өдрийн 06 тоот тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 74755.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд гүйцэтгэлээр 92416.1 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 17660.3 мянган төгрөгөөр буюу 123.6 хувиар давуулан биелүүлсэн байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого буюу ЗДТГазрын 105.4 мянган төгрөг нь ЗДТГазрын харилцах дансаар төвлөрсөн мэдээ тайланд нэгтгэгдсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 36095.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба жилийн эцэст 13951.7 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн. Төрийн сангийн мэдээллийн системээс гаргасан үлдэгдэлээр орон нутгийн төсвийн 140200910 тоот дансанд байна. Орон нутгийн орлогын дансны орлого, зарлагын гүйлгээ 1684.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Тайлант оны орлого, эх үүсвэрийг тооцоход:

Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 92416.1 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 211102.3 мянган төгрөг, тусгай зориулалтын

шилжүүлгээр 1015696.8 мянган төгрөг, ОНХСанд аймгийн төсвөөс 128010.4 мянган төгрөг, БХСанд 9000.0 мянган төгрөг, халамжийн санхүүжилт 149138.1, ХЭДСангаас СХСанд 60000.0 мянган төгрөг нийт 1665363.7 мянган төгрөг төвлөрсөн байна.

Төрийн сангийн шилжүүлгээр санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 145300.0 мянган төгрөг, ИТХуралд 28278.0 мянган төгрөг, Багт 37524.3 мянган төгрөг нийт 211102.3 мянган төгрөгийн санхүүжилтийг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазар 94134.7 мянган төгрөгийг, Баг 186.4 мянган төгрөг, ИТХурал 18554.3 мянган төгрөг бүгд 112875.4 мянган төгрөг олгосон байна. БХСанд 9000.0 мянган төгрөг, ОНХСанд 143765.0 мянган төгрөг тус тус олгогдсон байна. НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний үлдэгдэл 1079.2 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 605906.3 мянган төгрөг, Цэцэрлэгт 152910.8 мянган төгрөг, Эмнэлэгт 200038.6 мянган төгрөг, Соёлын төвд 56841.0 мянган төгрөг, нийт 1015696.7 мянган төгрөг шилжүүлсэн ба дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 12462.2 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Халамжийн санд 149138.1 мянган төгрөг төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 109886.4 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 34526.7 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 4040.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685.0 мянган төгрөг зарцуулсан.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтийг ЗДТГазарт 20165.5 мянган төгрөгөөр нэгтгэснийг аудитын явцад залруулж 7300.4 мянган төгрөгөөр, Сургууль 2343.8 мянган төгрөг, ЭМТөв 2230.0 мянган төгрөг, нийт 11874.2 мянган төгрөгийг орлогыг бүрэн зарцуулж үлдэгдэлгүйгээр нэгтгэсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 105.4 мянган төгрөг, Соёлын төв 980.7 мянган төгрөг, ЭМТөв 348.7 мянган төгрөг, Сургууль 180.0 мянган төгрөг, нийт 1614.8 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Сум Хөгжлийн Санд 60000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд НЕҮйлчилгээний байгууллагууд 1079.1 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 105424.7 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 36095.3 мянган төгрөг нийт 142599.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 178962.6 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 13951.7 мянган төгрөг нийт 192914.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгааатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд болон эцэст авлагагүй нэгтгэсэн. Аудитын явцад СХСангийн зээлийн авлага 147503.0 мянган төгрөгийг авлагаар нэмж нэгтгүүлсэн. Харин СХСангийн оны эхний 77700.0 мянган төгрөгийн авлага нэгтгэгдээгүй байна.

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 74453.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 216598.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 199729.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 91322.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 3634913.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 138110.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 8091.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 3764932.5 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тодруулга тайлан хэвлэж ирүүлээгүй байна

Тусгай зориулалтын сангууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд “Засгийн газрын тусгай сангуудын тухай хууль”-ийн 5.4-т заагдсан дараах тусгай сангууд байна. Сум хөгжүүлэх сан, Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сан, Байгаль нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эм эргэлтийн сан гэсэн 6 сан байна. Сумын хэмжээнд 6 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудын санхүүгийн тайланг аудитын явцад сан тус бүрээр нь гаргасан байна.

Сангуудыг тодруулахад:

Сум хөгжүүлэх сан

Сум хөгжүүлэх сан нь 2013 оны эхэнд харилцах дансандаа 71193.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. СХСангийн Мөнгөн гүйлгээний тайлангаар орлого эх үүсвэрийг 224868.8 мянган төгрөг тайлагнасан ба харилцах дансны эхний үлдэгдлийг $224868.8 - 71193.7 = 153675.1$ мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Үүнд:

1. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 60000.0 мянган төгрөг
2. Мянганы сорилын санд хамрагдсан билчээр худгийн бүлгүүдэд олгосон зээлийн хүүгийн эргэн төлөлт 861.8 мянган төгрөг
3. СХСангийн үндсэн зээлийн эргэн төлөлтөөр 72843.5 мянган төгрөг, зээлийн хүүнд 1992.5 мянган төгрөг нийт 74836.0 мянган төгрөг
4. Аймгийн 90 жилийн билетийн үнэ 2600.0 мянган төгрөг
5. Аймгийн 90 жилийн ойн хандивт төсөвт байгууллагуудын ажиллагсдаас 1 өдрийн цалинд 2305.3 мянган төгрөг, аж ахуйн нэгжүүдээс 12800.0 мянган төгрөг
6. МХСанд төвлөрөх өвс тэжээлийн 265.5 мянган төгрөг нийт 153668.6 мянган төгрөг

Тайлант онд МГТайлангаар 172190.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн. Үүнд

1. СХСангаас 2013 онд 160300.0 мянган төгрөгийн зээлийг шинээр нэмж олгосон
2. Аймгийн ОНХСангийн дансанд 90 жилийн ойтой холбогдсон 11625.3 мянган төгрөг
3. Сумын МХСанд 265.5 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

СХСангийн өмнөх оны зээлийн авлага 77700.0 мянган төгрөгнөөс тайлант онд 4000.0 мянган төгрөгийн үлдэгдэл үлдэж бусад нь бүрэн барагдсан. Оны эцэст 147503.9 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагыг тайлагнаагүй байсныг аудитын явцад нэмж тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх сангаас зээлийг олгохдоо сумын СХСангийн зөвлөлийн хуралдаанаас хэлэлцэн зээлийг олгох шийдвэр гаргаж, сумын Засаг даргын орлогч зээлдэгч нартай гэрээ байгуулдаг. Гэрээг үндэслэн санхүү ня-бо гүйлгээг хийдэг. Зээлийн эргэн төлөлтөнд сумын ЗДаргын орлогч хариуцан хяналт тавьдаг ба хугацаа хэтрэсэн зээлийг мэдээллийн самбарт тавьж ажилладаг байна. Зээлийн барьцаанд үл хөдлөх хөрөнгийн бичиг гэрчилгээг эх хувиар авдаг зээлдэгч нарын бусад банк байгууллагат өр авлагийн судалгааг тоотоор авдаг байна.

Мянганы сорилтын сангаас олгосон зээлийн хүүнээс 861.8 мянган төгрөг төвлөрсөн ба тайлант онд хичнээн төгрөг төвлөрөх нь тодорхойгүй байгаа тул нийт зээл зээлийн хүүгийн авлагыг бүртгэж тайлагнах нь зүйтэй байна.

Байгаль орчин хамгаалах сан

Тус сан нь 2013 оны эхэнд харилцах дансны үлдэгдлийг 5943.5 мянган төгрөгөөр тайлагнасан ба тулган баталгаажуулалтаар өмнөх оны үлдэгдэл 1943.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба аймгаас ирсэн санхүүжилтийн 4000.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн тайлагнасан гэж аудитын явцад залруулсан болно. Оны эцэст харилцах дансандаа 5866.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй МГТайлангаар $13193.5 - 1943.5 = 11250.0$ мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнасан. Үүнд аймгийн санхүүгийн дэмжлэг 9000.0 мянган төгрөг, биологийн кабинет тохижуулахад 2000.0 мянган төгрөгийн, 250.0 мянган төгрөг нь АЗДЗахирамжаар санхүүжилт ирсэн. Дараах Аймгаас байгаль хамгаалах зорилгоор ирсэн санхүүжилтээс 3 багийн булгийн эх хаших тохижилтонд 4500.0 мянган төгрөг, хогийн цэг булж цэвэрлэхэд 486.0 мянган төгрөгийн шатахууны зардал, Хогийн сав авахад 501.0 мянган төгрөг, 2-догч түүхий эд авахад 1000.0 мянган төгрөг, нохой устгахад 840.0 мянган төгрөг нийт 7327.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна. Хогийн 3 ширхэг савыг нэг бүрийг 167.0 мянган төгрөгөөр ЗДТГазрын хөрөнгөнд бүртгэсэн.

БОНССан

Санхүүгийн тайлангийн МГТайлангаар 15753.0 мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнасан ба үүнд оны эхний үлдэгдэл 15303.0 мянган төгрөгийг оруулан тайлагнасан ба 450.0 мянган төгрөгийн орлого 4 компаниас төвлөрсөн байна. Зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Мал хамгаалах сан

Тус сан нь 2013 оны эхэнд харилцах дансны үлдэгдэл 11367.4 мянган төгрөгийг эх үүсвэрт урсгал орлогоор тайлагнасан ба тайлант онд 4509.5 мянган төгрөгийн орлого нь өвс тэжээл борлуулсны орлого төвлөрч 5285.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 7191.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайлангаар цэвэр мөнгөн гүйлгээ 10591.4 мянган төгрөг ба үлдэгдлийг хасч тооцон 3400.0 мянган төгрөг зөрүүтэй байна. Аудитын явцад тулган шалгахад 3400.0 мянган төгрөгийн зарлагыг орхигдуулсан нь нотлогдсон.

Энэбишээс өвсний үнэ $760 + 1430 + 2100 + 588 + 650 + 286 + 530 = 6344.0 - 4509.5 = 1834.5$ мянган төгрөгөөр орлого дутуу тайлагнасан

Өвс тэжээлийн бараа материалын тайлан байхгүй. Санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайлангаар бичиг хэргийн материалд 350.0 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээ тайлагнасан ба ня-бо-гчоос тодруулах хужирын орлого зарлагыг тайлагнасан байна.

Аж ахуйн материалд 6670.0 мянган төгрөгийн орлого, 6270.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст 400.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь өвс тэжээлийн борлуулалт байна. Тооллогын бүртгэл үзүүлээгүй ба ня-гчоор 100 боодол өвс ширхэг нь 4000 төгрөгийн үнэтэй байгаа гэсэн.

Өвсний тооцоо оны эхэнд 320.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан

Зуунмод УНСалбараас өвс	<u>1400.0</u>	2013.01.16-нд 400 боодол
Тосон овоо ХХК-аас өвс	<u>2000.0</u>	2013.01.16-нд
Хунжүй ХХК-аас өвс	<u>2100.0</u>	2013.10.24-нд 500 боодол 4200 төгрөг
Батхянган ХХК тэжээл	<u>1170.0</u>	2013.04.23-нд
Хужир Ж.Гантулга	350.0	2013.01.29-нд
орлого нийт	<u>7020.0</u>	

Материалын тайлан хийгээгүй байхгүй Борлуулалт $320.0+7020.0-400.0=6940.0-6344.0=596.0$ дутуу зэргийг залруулж тооцоог дахин бодож ирүүлэхээр албан шаардлага бичлээ.

ХААН банкинаас 2013.01.17-нд чекээр 1165536 төгрөг авснаас Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан хийгээгүй баримт хавсаргасан байна. Үүнд:

2013.01.17-нд 3.Батболдод 650.0 мянган төгрөгийг тээврийн зардалд

2013.02.22-нд чекээр 500.0 мянган төгрөг бэлнээр ХААН банкнаас авсан

2013.02.22-нд 3.Батболдод 750.0 мянган төгрөгийг тээврийн зардалд

2013.03.22-нд Энэбишээс 265550 төгрөгийг 141055401 дансанд шилжүүлсэн буруу шилжүүлж дараа залруулагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сан

Тайланд онд орон нутгийн иргэдээс авсан санал асуулгаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн 16 ажлын хүрээнд 234000.0 мянган төгрөг төсөвлөгдсөн байна. Эрэмбэлэгдсэн ажлуудаас Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнд 60.0 сая төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг 18.0 сая төгрөг, гүүр засварлах 30.9 сая төгрөг, худаг засварлах 2.0 сая төгрөг, зам засварлах 12.2 сая төгрөг, халуун ус 9.1 сая төгрөг, физикийн кабинет тохижуулах 6.8 сая төгрөг, цэвэр усны шугам татах 30.0 сая төгрөг, Хогийн цэг тохижуулах 15.0 сая төгрөг, Ёслол хүндэтгэлийн талбай 5.0 сая төгрөг нийт 189.0 сая төгрөгийн ажил огт хийгдээгүй байна.

Дараах ажлууд хийгдэж 36837.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд

1. Өвс тэжээл агуулах барихад 7540.0 мянган төгрөг /дуусаагүй/
2. Сумын баяр наадмын зардал 6000.0 мянган төгрөг
3. Мал угаах зөөврийн хашаа 4680.0 мянган төгрөг /дуусаагүй/
4. Хог усны машины засвар 3000.0 мянган төгрөг
5. Гэр хороололыг хаягжуулах 2232.0 мянган төгрөгийг /дуусаагүй/
6. Ёслол хүндэтгэлийн өргөө 13385.0 мянган төгрөг дууссан орлогоор ЗДТГазарт бүртгэсэн байна. Тендерийн материал үзээгүй болно.

2013 оны жилийн эцсээр 91173.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Эм эргэлтийн сангийн талаар:

ЭЭСангийн санхүүгийн тайлан баримт, ЭМТөвийн тайлантай хамт аудитор Г.Бадарууган шалгасан болно.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Нярав эд хариуцагчийн тайланг тогтмол хийлгэж хэвших

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн Сумын нэгдсэн тайланд илүү нэгтгэсэн 151503.0 мянган төгрөгийг залруулсан болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

1. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

2. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар
2014.03.21